

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны ... дугаар
сарын-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Жагсаалт, төлбөрийн арга, журмыг шинэчлэн батлах тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 14 дүгээр зүйлийн 14.8.6, 14.9.8, 14.9.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-г нэгдүгээр, “Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох эмийн үнийн хөнгөлөлтийг санхүүжүүлэх төлбөрийн арга, журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.
2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга /Ц.Батбаатар/-д даалгах нь:
 - 2.1. Энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт үзүүлэх эмийн үнийн дээд хязгаарыг хүлээн зөвшөөрсөн эмийн сантай гэрээ байгуулах, баталсан үнийн дээд хязгаарыг мөрдүүлэх, гэрээ бүхий эмийн сангуудад эмийн жагсаалтыг хүргэх, мэдээлэх, сурталчлах ажлыг шуурхай зохион байгуулах;
 - 2.2. Хөнгөлөлттэй эмийн батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулах, жор бичилтийн оновчтой байдал, иргэний баталгаажилтыг нэмэгдүүлэх, зөрчилтэй жорыг илрүүлэх цахим системийн хөгжүүлэлтийг тасралтгүй хийж сайжруулах;
 - 2.3. Жагсаалт, журмын дагуу цахим програм хангамжид нэмэлт өөрчлөлт оруулах, эмийн үнийн бүрдлийг нийтэд ил тод болгож, иргэний хяналтыг сайжруулах талаар хөгжүүлэлт хийх;
 - 2.4. Энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан эмийн жагсаалтад өөрчлөлт оруулах шаардлага үүссэн тохиолдолд санал боловсруулан ЭМДҮЗ-ийн хурлаар тухай бүрт нь шийдвэрлүүлэх;
 - 2.5. Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөх эмийн нэг удаагийн тун, эмчилгээний үргэлжлэх хугацааг олон улсын эмнэлзүйн удирдамж /UpToDate/-д зөвлөсний дагуу цахим системд тогтмол шинэчлэх;
 - 2.6. Хөнгөлөлттэй эмийн батлагдсан төсвийн хүрээнд гэрээ бүхий эмийн сангуудыг төсвийн жилд санхүүжүүлэх;
3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /П.Алтанцэцэг/-т даалгах нь:
 - 3.1. Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн импорт, үйлдвэрлэлийг тасалдалгүй байлгахад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах;
 - 3.2. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эмийн сангуудад эмийн нөөц бүрдүүлэлтийг хангалттай байлгах асуудалд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах;

- 3.3.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд заасны дагуу хөнгөлөлттэй эмийг нэг эх үүсвэрээс худалдан авах ажлыг зохион байгуулах, нэр төрлийг нэмэгдүүлэх;
4. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгах нь:
- 4.1.Өөрийн байгууллагын эмч нарыг хөнгөлөлттэй эмийн жор бичих цахим эрхээр хангах, цахим жор бичүүлж буй иргэнийг ХҮР системээр баталгаажуулах нөхцлийг бүрдүүлэх;
- 4.2.Эрүүл мэндийн байгууллагын шатлалаас үл хамааран даатгуулагчид шаардлагатай үед нь хөнгөлөлттэй эмийн жороор үйлчлэх;
5. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ бүхий эмийн сангийн дарга, захирал нарт даалгах нь:
- 5.1. Өөрийн байгууллагын хэрэглэж буй цахим системийг ЭМДЕГ-аас хүргүүлж буй гарын авлагын дагуу цаг тухайд нь хөгжүүлэх, иргэнийг ХҮР системээр баталгаажуулах нөхцлийг бүрдүүлэх;
- 5.2. Иргэний сонголт хийх эрхийг хангах зорилгоор худалдааны нэршлийн эмийн нэр төрлийг нэмэгдүүлэх, 2 талтай дэлгэцийг байршуулах;
- 5.3. Энэхүү тогтоолоор баталсан эмийн үнийн дээд хязгаар, иргэний төлөх дүнг баримтлан иргэнд хөнгөлөлттэй эмийн жорыг тасралтгүй, хүндрэл чирэгдэлгүй олгох;
- 5.4. Засгийн газраас эмийн талаар баримталж буй бодлогыг дэмжин Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар болон Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай хамтран ажиллах.
6. Энэхүү тогтоолын хүрээнд төрийн захиргааны байгууллагаас эмийн худалдан авалтын үйл ажиллагаанд оролцох, эмийн сан болон эм ханган нийлүүлэх байгууллагатай аливаа төрлийн гэрээ хийн хамтран ажиллах үед авлига, албан тушаал, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, урьдчилан сэргийлж ажиллах ба түүнтэй холбоотой хариуцлагыг холбогдох хуулийн дагуу тооцно.
7. Энэхүү тогтоолыг 2026 оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн мөрдөнө.
8. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 11 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
9. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн ажлын алба /Ц.Сарантуяа/-д даалгасугай.

ДАРГА

Ж.ЧИНБҮРЭН

Эрүүл мэндийн даатгалын үндэсний
зөвлөлийн 2026 оны дугаар сарын ... -ны
өдрийн ... дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ЭМИЙН ҮНИЙН ХӨНГӨЛӨЛТ ОЛГОХ, САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь эрүүл мэндийн даатгалын сан (цаашид “ЭМДС” гэх)-аас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эм (цаашид “Хөнгөлөлттэй эм” гэх)-ийн жагсаалт, түүний үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг тодорхойлох, хөнгөлөлттэй эмээр үйлчлэх, санхүүжүүлэх, хяналт тавихтай холбогдох харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Хөнгөлөлт үзүүлэх өвчин эмгэгийг тодорхойлох, эмийн нэр төрөл сонгох, үнийн дээд хязгаар, хөнгөлөлтийн хэмжээг тогтоох

2.1. Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт олгохдоо Монгол Улсын хүн амын дунд нийтлэг тохиолддог, даатгуулагчийг эмээс үүдсэн санхүүгийн эрсдэлд оруулдаг амбулаториор эмчлэх боломжтой өвчин эмгэгийг сонгох, тухайн өвчин эмгэгийг эмчлэхэд зөвлөсөн эмийг олон улсын эмнэлзүйн удирдамж (Uptodate)-аас сонгох үндсэн зарчмыг баримтална.

2.1.1 Эмчилгээний эмэнд нь үнийн хөнгөлөлт олгох өвчин эмгэгийг архаг, хурц, хүүхэд болон настанд зонхилон тохиолдох гэсэн 4 бүлгийн хүрээнд нарийвчилсан аргачлалд заасан шалгуурын дагуу сонгоно.

2.1.2. Эмчилгээний эмэнд нь үнийн хөнгөлөлт олгох өвчин эмгэгт дараах төрлийн өвчнүүд хамаарахгүй, Үүнд:

- Эмнэлэгт шууд хэвтүүлэн эмчлэх заалттай цочмог өвчин
- Шүдний өвчин
- Гэмтлийн яаралтай тусламж үзүүлэх шаардлагатай өвчин
- Амбулаториор эмчлэгдэхгүй халдварт өвчин

2.2. Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох эмийн үнийн дээд хязгаарыг тогтоохдоо дараах мэдээллийг ашиглаж томъёоллын дагуу тооцно, Үүнд:

ҮДХ = Эмийн үнийн дээд хязгаар

ГҮ = Гаалийн үнэ¹

ГАТ = Гаалийн албан татвар, 5%

БЖДҮ = Бүлгийн жигнэсэн дундаж үнэ

БНХ = Бөөний нэмэгдэл хувь, 15%

ЖНХ = Жижиглэнгийн нэмэгдэл хувь, 20%

НӨАТ = Нэмэгдсэн өртгийн албан татвар, 10%

БНИД = Тухайн бүлгийн эмийг гаалиар импортолсон нийт мөнгөн дүн

БНИТ = Тухайн бүлгийн эмийг гаалиар импортолсон нийт тоо ширхэг

ОУН = Эмийн олон улсын нэршил

СТ = Эмийн савлагааны төрөл

ИУТ = Эмийг импортолсон улсын төрөл

¹ Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 10 дугаар зүйл

Бүлэг үүсгэх:

Бүлэг = ОУН + Тун + Хэлбэр + СТ + ИУТ

СТ = Нэг удаагийн **эсвэл** Олон удаагийн

ИУТ = Эмийн хатуу зохицуулалттай орон **эсвэл** Бусад орон

БЖДҮ = БНИД / БНИТ

Томьёолол:

$$\text{ҮДХ} = (\text{ГҮ} + \text{ГҮ} * \text{ГАТ} + \text{БЖДҮ} * \text{БНХ} + (\text{БЖДҮ} * \text{БНХ}) * \text{ЖНХ}) * \text{НӨАТ}$$

2.3. Эмийн хатуу зохицуулалттай орон гэж Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн эмийн зохицуулалтын эрх бүхий байгууллагатай гадаад улсыг хэлэх ба эдгээр улсын эмийн чанар, аюулгүй байдал болон үр нөлөөтэй байдал нь олон улсын стандартыг хангасан байдаг.

2.4. Нэг удаагийн савлагаатай эм гэж шахмал, капсул болон түүнтэй ижил төрлийн хэлбэртэй, нэг болон түүнээс олон өдрийн хэрэглээг агуулсан ширхэгээр савласан эмийг хэлнэ.

2.5. Олон удаагийн савлагаатай эм гэж хоолойн цацлага, сироп, хөвмөл, тосон түрхлэг, дусал болон түүнтэй ижил төрийн хэлбэртэй, 5 болон түүнээс дээш өдрийн хэрэглээг агуулсан бүхлээр нь савласан эмийг хэлнэ.

2.6. Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт олгох хэмжээг дараах зарчмыг баримтлан тогтооно, Үүнд:

2.6.1. Дараах өвчний үед хэрэглэх эмийн хөнгөлөлтийн хэмжээг бүлэг дэхь хамгийн хямд үнэтэй эмийн үнээс хувиар тооцон тогтооно.

- Зүрх судасны тогтолцооны өвчин эмгэг – 70%
- Чихрийн шижингийн 2 дугаар хэв шинж – 70%
- Хавдар – 70%
- Элэгний В вирусийн халдвар – 70%
- Хүүхдийн амьсгалын замын өвчин – 70%

2.6.2. Дээрх өвчин эмгэгээс бусад өвчний үед хэрэглэгдэх эмийн хөнгөлөлтийн хэмжээг бүлэг дэхь хамгийн хямд үнэтэй эмийн үнийн 50 хувиар тооцон тогтооно.

2.7. Засгийн газраас хэрэгжүүлж буй хямд үнэтэй, чанартай эмийг иргэнд хөнгөлөлттэй үнээр олгох бодлогыг дэмжих зорилгоор Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэхь хэсэгт заасан аргаар худалдан авсан эмийн үнийн дээд хязгаар, хөнгөлөлтийн хэмжээг дээрх томьёоллоос ялгаатайгаар тогтоож болно.

2.8. Энэхүү журмын 2.6.1-д заасан өвчний хүрээнд хамтын төлбөрийн хэмжээнд “хамтын төлбөрийн тааз”-ыг даатгуулагч бүрээр хуримтлуулан тооцож давсан тохиолдолд тухайн даатгуулагчийн төлөх хамтын төлбөрийн хэмжээг бууруулан тооцно.

Хоёр. Хөнгөлөлттэй эмийн цахим жор бичих, олгох

3.1. Хөнгөлөлттэй эмийн жор бичих цахим эрхийг тухайн эрүүл мэндийн байгууллагын “Админ” нь эмч нарт олгох ба админ эрхийг Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас эмнэлгүүдэд олгоно.

3.2. Админ нь дараах тохиолдолд эмчийн хөнгөлөлттэй эм бичих цахим эрхийг хаана.

- 3.2.1. Тухайн эмч ажлаас чөлөөлөгдсөн;
- 3.2.2. Тухайн эмчийн эмчлэх эрхийн лиценз цуцлагдсан;
- 3.2.3. Хууран мэхлэх үйлдэл, оролдлого хийсэн нь нотлогдсон;
- 3.2.4. Бусад холбогдох хууль болон гэрээний заалтад үндэслэн

- 3.3. Хөнгөлөлттэй эмийн жагсаалтад байх урт хугацаанд тогтмол уух шаардлагатай архаг өвчний зарим төрлийн эмийг холбогдох тушаал, журам, стандартад заасан бол 1-ээс дээш сарын хэрэглээгээр жоронд бичиж болно.
- 3.4. Хөнгөлөлттэй эмийн жорыг эмчлэгч эмч болон насанд хүрсэн иргэний хурууны хээгээр баталгаажуулах ба хурууны хээний мэдээллийг ХҮР системээс шалгана. Иргэн нь хурууны хээ уншуулах боломжгүй тохиолдолд тоон гарын үсэг, бүртгэлтэй утасны дугаарт ирэх нэг удаагийн код, И-Монголиа системийн аль нэгээр нь баталгаажуулна.
- 3.5. Хөнгөлөлттэй эмийн цахим жорыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ бүхий бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагын эмч нар бичиж болно.
- 3.6. Хөнгөлөлттэй эмийн жорыг бичихдээ эмчлэгч эмч нь зовуурь, үзлэг, оношилгоо шинжилгээг дүгнэж жорын цахим маягтад тодорхой бичнэ.
- 3.7. Хөнгөлөлттэй эмийн жорыг иргэнд бичихдээ олон улсын эмнэлзүйн удирдамжид зөвлөсөн нэг удаагийн тун, эмчилгээний үргэлжлэх хугацаа, эм хоорондын нийцлийг мөрдөнө.
- 3.8. Хөнгөлөлттэй эмийн жорыг зөвхөн эмнэлзүйн үндэслэлтэй өвчтөнд бичих ба онош хувиргаж жор бичсэн тохиолдолд холбогдох хууль, журам болон гэрээний заалтын дагуу хариуцлага тооцно.
- 3.9. Хөнгөлөлттэй эмийн жорын хүчинтэй хугацаа нь Монгол Улсын жорын стандартад заасны дагуу байх ба иргэн нь тухайн хүчинтэй хугацааны дотор эмийн сангаас эмийг худалдан авна.
- 3.10. Хөнгөлөлттэй эмийн жоронд бичсэн нэг болон түүнээс дээш төрлийн эмийг нэр төрөл, тоо хэмжээгээр нь хэд хэдэн эмийн сангаас хэсэгчлэн авах боломжтой байна.
- 3.11. Алдаатай бичсэн хөнгөлөлттэй эмийн цахим жор дахь эмийг иргэн худалдан аваагүй тохиолдолд тухайн алдаатай жорыг цуцлах эрх нь эмчлэгч эмчид байна.
- 3.12. Хөнгөлөлттэй эмийг олгох эмийн сан нь хоёр талт дэлгэцийг иргэнд ил тод харагдахуйц байршуулах ба хөнгөлөлттэй эмийг худалдан авах үед эмийн худалдааны нэршлээс сонголт хийх боломжийг бүрдүүлсэн байна.
- 3.13. Хөнгөлөлттэй эмийг олгосон эмийн сан нь иргэнд холбогдох хуульд заасны дагуу НӨАТ-ын сугалаа бүхий и-баримтыг заавал хэвлэж өгөх ба баримт дээрх мэдээлэлд эм худалдан авсан иргэн нь хяналт тавина.
- 3.14. Хөнгөлөлттэй эмийн жоронд Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан сэтгэц нөлөөт эмийг лавлагаа шатлалын эмнэлгийн эмч бичсэн тохиолдолд амбулаторын эрхлэгчийн тоон гарын үсгээр, Өрх, сумын эмнэлгийн эмч бичсэн тохиолдолд даргын тоон гарын үсгээр давхар баталгаажуулна.

Дөрөв. Хөнгөлөлттэй эмийн нэхэмжлэлийг хүлээн авах, хянах, санхүүжүүлэх

- 4.1. Хөнгөлөлттэй эмээр үйлчлэх эмийн сан нь өөрийн программ хангамжаар дамжуулан иргэнд олгосон жорын мэдээллийг Эрүүл мэндийн даатгалын нэхэмжлэл хүлээн авах системрүү системрүү цахимаар бодит цагийн горимд нийцүүлэн илгээнэ.
- 4.2. Хөнгөлөлттэй эмийн жорын нэхэмжлэлд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас хийх хяналт нь цахим хяналт болон газар дээрх хяналт гэсэн 2 төрөлтэй байх ба жорын нэхэмжлэл бүрт цахим хяналтыг хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд газар дээрх хяналтыг хийнэ.
- 4.3. Эрүүл мэндийн даатгалын жорын цахим системд жор бичих үед дараах цахим хяналт хийгдэнэ. Үүнд:
 - 4.3.1. Эмчийн эмчлэх эрхийн лиценз нь хүчинтэй эсэх;
 - 4.3.2. Эмч нь онош хувиргаж жор бичиж байгаа эсэх;

- 4.3.3. Жор бичүүлж буй иргэн нь эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ бүрэн төлсөн эсэх;
- 4.3.4. Тухайн эм нь хэрэглэх хүн амын бүлэг, насанд тохирч буй эсэх;
- 4.3.5. Эмч нь Монгол Улсын жорын стандартыг баримталж байгаа эсэх;
- 4.3.6. Эмийн бүлэг, үйлдэл, найрлагыг давхардуулан бичиж байгаа эсэх;
- 4.3.7. Тухайн өвчин эмгэгийг эмчлэх олон улсын эмчилгээний удирдамжид зөвлөсөн эмийн нэг удаагийн тун, хоногийн тун, эмчилгээний нийт хугацааг баримталж байгаа эсэх;
- 4.3.8. Эмчийн бичиж буй жоронд эм-эмийн харилцан үйлчлэл байгаа эсэх;
- 4.3.9. Эмийн сангаас олгож буй хөнгөлөлттэй эмийн жор нь хүчинтэй эсэх;
- 4.3.10. Эмийн сангаас хөнгөлөлттэй эмийн жоронд эмчийн бичсэн эмийг зохих хэлбэр, тун, тоо хэмжээгээр нь олгож буй эсэх;
- 4.3.11. Нэг цаг хугацаанд нэг жорын нэхэмжлэлийг олон удаа давхардуулан нэхэмжилсэн эсэх;
- 4.3.12. Хөнгөлөлттэй эмийн жорыг бичсэн эмнэлэг болон борлуулсан эмийн сангийн байршлын хувьд хэт зөрүүтэй байдал байгаа эсэх;
- 4.4. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас дараах тохиолдолд эрүүл мэндийн байгууллага болон эмийн санд газар дээрх хяналтыг хийнэ. Үүнд:
 - 4.4.1. Иргэн, даатгуулагчаас хөнгөлөлттэй эмийн үйлчилгээг аваагүй талаар гомдол ирүүлсэн тохиолдолд;
 - 4.4.2. Тухайн эмийн сангийн авч буй санхүүжилтын хэмжээний өсөлт өмнөх саруудын дүнтэй харьцуулахад сэжигтэй тохиолдолд хүрсэн болон түүнээс давсан тохиолдолд;
 - 4.4.3. Ерөнхий нэршлийн эмэнд багтсан худалдааны нэршлийн эмүүдээс зөвхөн нэг худалдааны нэршлийн эмийг давамгайлж нэхэмжилж буй тохиолдолд;
 - 4.4.4. Иргэн, даатгуулагчаас бусад холбогдох асуудлын хүрээнд гомдол, санал ирүүлсэн тохиолдолд;
 - 4.4.5. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус байдлаар, эсвэл иргэн, даатгуулагчийн санал хүсэлтээр тухайн эмийн сангийн хөнгөлөлттэй эмийн нэр төрөл болон тоо хэмжээний нөөцийн бүрдүүлэлттэй холбоотой гомдол, санал ирсэн тохиолдолд;
 - 4.4.6. Гэрээнд заасан бусад заалтыг үндэслэн шаардлагатай тохиолдолд;
 - 4.4.7. Нэг хүнд ноогдох жорын мөнгөн дүн нь хэт өндөр тохиолдолд;
- 4.5. Энэхүү журмын 4.3 дахь хэсэгт заасан зарим тохиолдлыг “Зөрчилтэй жорын сан”-д бүртгэж авах ба эрүүл мэндийн байгууллага болон эмийн сангийн гэрээг дүгнэх үед зөрчлийн санд бүртгэгдсэн жорын мөнгөн дүнг тухайн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээс суутгана.
- 4.6. Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн санд дараах тохиолдолд санхүүжилтийг олгохгүй. Үүнд:
 - 4.6.1. Эмийн сангийн ашигладаг програм хангамжийн алдаанаас болж илгээгээгүй нэхэмжлэлийг;
 - 4.6.2. Эмийн сангийн ашигладаг програм хангамж болон төлбөрийн системийг заасан хугацаанд хөгжүүлээгүй, шинэчлээгүй шалтгааны улмаас илгээгээгүй нэхэмжлэлийг;
 - 4.6.3. Бодит цагийн горимоор илгээгээгүй, хоцроосон нэхэмжлэлийг;
 - 4.6.4. Гэрээнд тусгайлан зааж өгсөн тохиолдлоос бусад шалтгааны улмаас илгээгээгүй нэхэмжлэлийг;
 - 4.6.5. Энэхүү журмын 4.3, 4.4 дэхь хэсэгт заасан тохиолдлыг хянаж үзээд зөрчилтэй жор эсэх нь хяналт, шалтгалтаар илэрсэн үед.

4.7. Хөнгөлөлттэй эмийн хүртээмжийг сайжруулах зорилгоор гэрээт эмийн сангийн байршил, алслагдмал байдлыг харгалзан “бүсийн коэффициент” тооцон санхүүжүүлж болно.

Тав. Бусад зохицуулалт

5.1. Хөнгөлөлттэй эмийн тусламж, үйлчилгээний хүрээнд харилцагч талууд дараах заалтыг мөрдлөг болгон ажиллана.

5.1.1. Гэрээ бүхий эмийн сан:

- 5.1.1.1. Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн үнийн дээд хязгаарыг хэтрүүлж, даатгуулагчаас нэмэлт төлбөр авахгүй байх;
- 5.1.1.2. Хөнгөлөлттэй эмийн жагсаалтад байх эмийн нөөцийг ерөнхий нэршлийн хувьд 80-аас доошгүй хувьтай байлгаж нөөцийг бүрдүүлэх, тоо хэмжээний хувьд үйлчлэх хүрээний хүн амын тоонд үндэслэн тооцох;
- 5.1.1.3. "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль"-д заасны дагуу төлбөрийн баримтыг даатгуулагчид тухай бүрт нь олгох;
- 5.1.1.4. Эмийн сангийн анхан шатны бүртгэл мэдээ, эмийн нэр төрөл, орлого, зарлагын програм хангамжтай байж, баримт, тайланг үнэн зөв хөтлөх;
- 5.1.1.5. Эм барих зөвшөөрөлгүй этгээдийг эм найруулах, бэлтгэх, шалгах, олгох үйл ажиллагаанд татан оролцуулахгүй байх;
- 5.1.1.6. Ашиг орлогоо нэмэгдүүлэх зорилгоор эмч, иргэнтэй хуйвалдан эм борлуулах, үр дүнгээр урамшуулах, түүнтэй адилтгах үйл ажиллагаанд татан оролцуулах, эмийг худалдааны нэршлээр даатгуулагчид илт санал болгож, сонголтыг хязгаарлах үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй байх;
- 5.1.1.7. Эрүүл мэндийн даатгалын байгууллагад эмийн сангийн стандарт, санхүүгийн болон хүний нөөц, бусад асуудлаар мэдээллийг үнэн зөв ирүүлэх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;
- 5.1.1.8. Төрийн хяналт шалгалт хийх эрх бүхий хуулийн этгээд, албан тушаалтны тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх, шалгалтад холбогдолтой баримт бичгийг засварлахгүй байх, гэмтээхгүй, устгахгүй, шалгалтаас зайлсхийхгүй, хуурамч баримт бичиг гаргаж өгөхгүй байх;
- 5.1.1.9. Засгийн газраас баримталж буй бодлогыг хэрэгжүүлэх, хамтран ажиллах

5.1.2. Хөнгөлөлттэй эмийн жор бичих эмч, эрүүл мэндийн байгууллагад:

- 5.1.2.1. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.7-д заасан олон улсын эмнэлзүйн удирдамжийг баримтлах, даатгуулагчийн өвчний онош, нас, хүйсэнд тохирсон эм бичих;
- 5.1.2.2. Эрүүл мэндийн даатгалын цахим системд нэвтрэх эрхийг зөвхөн өөрөө ашиглах, өөрийн нэвтрэх эрхийг бусадтай хуваалцахгүй байх,
- 5.1.2.3. Эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сангаас жор бичилттэй холбогдсон биет болон биет бус урамшуулал авахгүй байх;
- 5.1.2.4. Тодорхой нэг эм ханган нийлүүлэх байгууллагын импортолж буй худалдааны нэршлийн эмийг иргэнд санал болгохгүй байх,
- 5.1.2.5. Жор бичих эрх бүхий эмч нь өөрийн үзлэг хийсэн өвчтөнд хөнгөлөлттэй эмийн жор бичиж өгөх үүрэгтэй
- 5.1.2.6. Жор бичих эрхтэй эмч нь ажлаас түр болон бүрэн чөлөөлөгдсөн үед байгууллагын “Админ”-даа мэдэгдэж хөнгөлөлттэй эмийн жор бичих эрхийг хаалгах;
- 5.1.2.7. Хөнгөлөлттэй эмийн жор бичих эрх бүхий эмч нь өөртөө, өөрийн хамаарал бүхий этгээд, төрөл садан, хамтран ажиллагчдаа аливаа эмнэлзүйн оношийн үндэслэлгүйгээр жор бичиж өөрийн болон эмийн сангийн ашиг орлогыг зохиомлоор нэмэгдүүлэх, даатгалын санг санаатайгаар хохироох, хувьдаа завших үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй байх;

5.1.3. Иргэн, даатгуулагчид:

- 5.1.3.1. Хөнгөлөлттэй эмээр үйлчлүүлэхдээ өөрийн мэдээллийг заавал баталгаажуулж байх;
- 5.1.3.2. Шаардлагагүй эм жоронд бичихийг эмчээс шаардахгүй байх;
- 5.1.3.3. Бусдад хэрэглэх эмийг өөрийн нэр дээр бичүүлэх, эсвэл эмчийн нэр дээр бичүүлэх талаар эмчээс шаардахгүй байх, дарамт шахалт үзүүлэхгүй байх;
- 5.1.3.4. Эрх бүхий байгууллага, хуулийн этгээд, албан тушаалтны тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх, эрүүл мэндийн байгууллага болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын нэр хүндийг гутаан доромжлох, гүтгэх, худал мэдээллийг олон нийтийн сүлжээгээр тараахгүй байх;

Зургаа. Журам зөрчигчид хүлээлгэх хариуцлага

- 6.1. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай болон бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ;
- 6.2. Эмийн сан нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс удаа дараалан гомдол ирүүлсэн тохиолдолд тухайн зөрчлийг арилгах хүртэлх хугацааны нэхэмжлэл хүлээн авахыг зогсоох, санхүүжилтийг түдгэлзүүлэх, дээрх зөрчил давтан илэрсэн, хуурамч баримт бичгээр санхүүжилт авсан нь нотлогдсон тохиолдолд гэрээг цуцлах, эрүүл мэндийн даатгалын санд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээ авах;
- 6.3. Тус журмын 5 дугаар бүлэгт заасан заалтыг зөрчсөн нь нотлогдсон тохиолдолд эрүүл мэндийн даатгалын байгууллага болон эмийн сан хооронд байгуулсан гэрээг цуцлах, тусгай зөвшөөрөл олгодог эрх бүхий байгууллагад мэдэгдэх;
- 6.4. Эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх цахим жор бичих эрх бүхий эмч нар энэхүү журмыг зөрчсөн, даатгуулагч иргэдээс ирүүлсэн гомдол үндэслэлтэй нь нотлогдсон тохиолдолд тухайн эмчийн "эрүүл мэндийн даатгалын цахим систем"-д нэвтрэх эрхийг хаах, эмчлэх эрхийн лицензийг олгодог эрх бүхий байгууллагад зөрчлийн талаарх мэдээллийг хүргэх, холбогдох эрүүл мэндийн байгууллагад олгох санхүүжилтийг бууруулах, хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авч олон нийтэд мэдээллэх;